

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МЕНЕЖМЕНТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-оос хөрөнгө оруулалтын менежментийн компани (цаашид “ХОМК” гэх)-ийн үйл ажиллагаанд тавих шаардлагыг тогтоох болон түүний бүтэц, зохион байгуулалт, эрх, үүргийг тодорхойлох, хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ байгуулах, сангийн хөрөнгийг удирдахтай холбоотой харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2. ХОМК Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 44.7.1, 44.7.2-т заасан үнэт цаасны хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ, үнэт цаасыг итгэмжлэн удирдах үйл ажиллагааг хавсран эрхлэхтэй холбоотой харилцааг Хорооноос баталсан “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх журам”-аар зохицуулна.

1.3. Энэ журмаар Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөрөнгө итгэмжлэн удирдагчийн үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулахгүй.

Хоёр. ХОМК-ийн үйл ажиллагаанд тавих шаардлага

2.1. Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэгч нь дараах шаардлагыг хангана:

2.1.1. хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ нь 200 сая төгрөгөөс доошгүй байх;

2.1.2. энэ журамд заасан бүтэц, зохион байгуулалт, хүний нөөцийг бүрдүүлсэн байх;

2.1.3. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 44.5-д заасан хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан, хөрөнгө оруулалтын зөвлөхүүд нь Хорооноос тодорхойлсон тохиромжтой этгээд байх;

2.1.4. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 44.3-т заасан хоёроос доошгүй хөрөнгө оруулалтын зөвлөхтэй байх;

2.1.5. сангийн хөрөнгөөр арилжаа хийх, брокерт захиалга өгөх, брокерийн баталгаажуулалтыг хүлээн авах, арилжааны төлбөрийг гүйцэтгэх, арилжааны гүйлгээтэй холбоотой мэдээллийг хадгалах, хөрөнгө оруулагчид мэдээлэл өгөх бэк оффис (back office)-ын программ хангамжтай байх;

2.1.6. үйл ажиллагаа явуулах ажлын байртай байх.

2.2. Энэ журмын 2.1.1-д заасан хувь нийлүүлсэн хөрөнгө нь зээлийн эх үүсвэрээс бусад мөнгөн хөрөнгөөс бүрдсэн байна.

Гурав. Бүтэц, зохион байгуулалт, хүний нөөцийн шаардлага

3.1. ХОМК гурваас доошгүй гишүүнтэй төлөөлөн удирдах зөвлөлтэй байх ба тэдгээрийн гуравны нэгээс доошгүй нь хараат бус гишүүн байна.

3.2. ХОМК-ийн гүйцэтгэх удирдлага, хөрөнгө оруулалтын зөвлөхүүд нь дараах шаардлагыг хангасан байна:

3.2.1. хуульд өөрөөр заагаагүй бол үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээд болон банк, даатгал, бусад санхүүгийн компанийн гүйцэтгэх удирдлага, бусад эрх бүхий албан тушаал хавсран эрхэлдэггүй байх;

3.2.2. банк, санхүүгийн зах зээлд гурваас доошгүй жил ажилласан туршлагатай, санхүү, эдийн засаг, хөрөнгө оруулалтын чиглэлээр мэргэшсэн байх;

3.2.3. тухайн компанитай гэрээгээр ажилладаг кастодиан, үнэлгээний болон аудитын компанийн эрх бүхий албан тушаалтан, үнэлгээчин, аудиторын холбогдох этгээд биш байх;

3.2.4. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 69.2-т заасан мэргэжлийн холбооноос үнэт цаасны зах зээл дээр хөрөнгө оруулалтын чиглэлээр ажиллах эрх авсан байх.

3.3. Энэ журмын 3.1-д заасан төлөөлөн удирдах зөвлөл дараах дүрэм, журам, төлөвлөгөөг баталсан байна:

3.3.1. төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам;

3.3.2. дотоод хяналтын журам;

3.3.3. ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах журам;

3.3.4. үйл ажиллагааны эрсдэлийг удирдах журам;

3.3.5. ёс зүйн дүрэм;

3.3.6. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасан шаардлагыг хангасан мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг бууруулах, удирдах талаар хэрэгжүүлэх төлөвлөгөө, эсхүл дотоод журам;

3.3.7. бизнесийн төлөвлөгөө;

3.3.8. бусад шаардлагатай журам.

3.4. ХОМК Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилт болон комплайнсын хяналтыг хэрэгжүүлэх нэгж, эсхүл хариуцсан ажилтантай байх бөгөөд түүнд төлөөлөн удирдах зөвлөл нь хяналт тавина.

3.5. ХОМК дотоод хяналт, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх нэгжтэй байх ба уг нэгжийн чиг үүрэг, үйл ажиллагааны онцлогтой холбоотой зохицуулалтыг энэ журмын 3.3.2, 3.3.4-т тус тус заасан журамд дэлгэрэнгүй тусгана.

3.6. ХОМК нь банк, санхүү, даатгал, үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэгч компаниудын нэгдлийн оролцогч компани бол тэдгээрийн хооронд олон нийтэд нээлттэй бус мэдээлэл алдагдах, аливаа сонирхлын зөрчил үүсэхээс сэргийлэх зорилгоор үйл ажиллагааг заагласан тогтолцоо (chinese wall)-г бүрдүүлсэн байх бөгөөд түүнд хяналт тавихтай холбоотой зохицуулалтыг дотоод хяналтын журамдаа тусгасан байна.

3.7. ХОМК хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах, маркетингийн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгөөр арилжаа хийх, үнэт цаасны брокерт захиалга өгөх зэрэг төлбөрийн өмнөх үйл ажиллагааг үнэт цаасны брокерийн баталгаажуулалтыг хүлээн авах, арилжааны төлбөрийг гүйцэтгэх, нягтлан бодох бүртгэл хөтлөх, тохируулга хийх, сангийн активыг үнэлэх, хөрөнгө оруулагчид мэдээлэх зэрэг үйл ажиллагаанаас тусгаарласан байна.

3.8. ХОМК-ийн комплайнс болон дотоод хяналтын үйл ажиллагаа нь тус тусдаа бие даасан байх ба үйл ажиллагаагаа төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагад шууд тайлагнаж ажиллана.

3.9. Энэ журмын 3.5-д заасан дотоод хяналтын нэгж нь үйл ажиллагаандаа зохистой засаглал, хараат бус байх зарчмыг мөрдөж ажиллах ба дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

3.9.1. компанийн үйл ажиллагааны бусад чиг үүргээс тусдаа байх;

3.9.2. аудитын ажлыг зохих ёсоор төлөвлөх, бүртгэх, хянах, түүнээс гарсан үр дүн, дүгнэлт, зөвлөмжийг тэмдэглэн хөтөлж, баримтжуулах;

3.9.3. аудитын тайланд онцолсон асуудлуудыг удирдлагад тухай бүр тайлагнаж шийдвэрлүүлэх.

3.10. ХОМК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүн, эрх бүхий албан тушаалтан, хөрөнгө оруулалтын зөвлөх, оноосон нэр өөрчлөхөд Хороонд урьдчилан мэдэгдэж, холбогдох өөрчлөлт оруулсны дараа бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад холбогдох өөрчлөлтийг хийлгэж, холбогдох нотлох баримтын хуулбарыг ажлын 5 өдөрт багтаан Хороонд хүргүүлнэ.

Дөрөв. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа

4.1. ХОМК хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахдаа үндэслэл бүхий тооцоо, судалгаанд суурилан, тодорхой аргачлалыг үндэслэнэ.

4.2. ХОМК нь урьдчилан тодорхойлсон хөрөнгө оруулалтын бодлого, эсхүл сангийн төрөл, хэлбэрийн дагуу хөрөнгө оруулалтын санг удирдах үүрэг хүлээсэн бол зөвхөн тухайн сангийн тодорхойлсон зорилт, хязгаарлалтад нийцүүлэн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа явуулна.

4.3. ХОМК нь сангийн бүх арилжааг гүйлгээний төрөл, хэмжээний хувьд зах зээлийг харгалзан үзсэний үндсэн дээр байж болох хамгийн сайн нөхцөлтэйгөөр гүйцэтгэн, сангийн активын үнэ цэнийг өсгөх зарчмыг баримтална.

4.4. ХОМК нь нэгж эрхийн хуваарилалтыг харилцагчдадаа шударга хуваарилж, хэн нэгэнд давуу эрх олгон хуваарилахгүй бөгөөд хуваарилалтын бүхий л явцыг баримтжуулан баталгаажуулсан байна.

4.5. ХОМК нь талуудын харилцан тохиролцоогүй нөхцөлөөр хийгдсэн, хамгийн сайн гүйцэтгэлийн нөхцөлөөр хийсэн, бусад байгууллагын хураамжийн түвшингээс доогуур байхаас бусад тохиолдолд өөрийн холбоотой этгээдээр дамжуулан харилцагчийн нэрийн өмнөөс арилжаа хийхгүй.

4.6. ХОМК нь зах зээлийн бодит үнэд суурилан сангийн активын үнэлгээг тогтмол хийх ба үнэлгээ хийх аргачлал нь харилцагчдад нээлттэй ил тод байна.

4.7. Хөрөнгө оруулалтын сантай холбоотойгоор ХОМК нь сангийн цэвэр хөрөнгийн үнийг үнэн, зөв тооцоолохдоо үнэлгээ нь тухайн сангийн бодлогын баримт бичгийн дагуу хийгдсэн эсэхэд хяналт тавьсан байна.

4.8. ХОМК нь хөрөнгө оруулалтын эрсдэлийн эх үүсвэр, нөхцөл байдал, эрсдэлийн түвшнийг удирдах, тодорхойлох, хэмжих эрсдэлийн удирдлагын арга хэрэгсэлтэй байна.

4.9. ХОМК нь санхүүгийн зах зээлийн гэнэтийн хямрал, давагдашгүй хүчин зүйлийн үед авч хэрэгжүүлэх бизнесийн тасралтгүй үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлнэ.

4.10. ХОМК нь хууль тогтоомжийн дагуу хөрөнгө оруулалтын үйл ажиллагаатай холбоотой хийсэн судалгаа, өгсөн зөвлөгөө болон авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны талаарх баримт бичгийг хадгалах ба бүртгэлийг аюулгүй найдвартай хадгалах үйл ажиллагааг дотоод дүрэм, журмаар тодорхой зохицуулсан байна.

4.11. ХОМК нь түүнд итгэмжлэгдсэн хөрөнгийн аюулгүй, найдвартай хадгалалтыг хариуцан, хөрөнгө хадгалах гэрээ байгуулсан кастодианы санхүүгийн чадавхад байнгын хяналт тавьж ажиллана.

4.12. ХОМК нь дотоод бүртгэлийг тооцооны байгууллага, банк, кастодиан, харилцагч болон брокер зэрэг гуравдагч этгээдүүдээс гаргасан бүртгэлтэй сар бүр тулган баталгаажуулах бөгөөд бүртгэлийн зөрүү гарсан тохиолдолд түүнийг тогтоож, залруулах үйл ажиллагааг гүйцэтгэн энэ талаар залруулгын бүртгэл хөтөлнө.

4.13. ХОМК нь хамтын хаалттай ХОС-д хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээг үзүүлдэг бол уг сангийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 5 хувиас доошгүй хэмжээгээр хөрөнгө оруулалт хийж, уг хязгаараас буурсан тохиолдолд нэмэлт хөрөнгө оруулалтыг тухай бүр санд оруулна.

4.14. ХОМК энэ журмын 4.13-т заасан оруулсан хөрөнгөө зөвхөн сангийн үйл ажиллагааны хугацаа дуусгавар болж, бүх өр төлбөрийг барагдуулан бусад нэгж эрх эзэмшигчдийн хөрөнгийг хуваарилсны дараа эргүүлж авна.

4.15. ХОМК Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 39.2-т заасны дагуу ХОС-ийн нягтлан бодох бүртгэлийг мэргэшсэн нягтлан бодогчоор гэрээний үндсэн гүйцэтгүүлж болох бөгөөд уг этгээд нь дараах шаардлагыг хангасан байна:

4.15.1. Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт (цаашид "ММНБИ" гэх)-ийн гишүүнчлэлтэй, Монгол Улсад бүртгэлтэй мэргэшсэн нягтлан бодогч байх;

4.15.2. мэргэжлийн ёс зүйн зөрчилгүй байх;

4.15.3. мэргэжлийн хариуцлагын даатгалд хамрагдсан байх.

Тав. Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ

5.1. ХОМК нь хөрөнгө оруулалтын сангийн активын удирдлагыг хэрэгжүүлэх хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ (цаашид "гэрээ" гэх)-г байгуулсны үндсэн дээр холбогдох үйлчилгээг үзүүлнэ.

5.2. Энэ журмын 5.1-д заасан гэрээнд дараах зүйлийг тусгана:

5.2.1. итгэмжлэн удирдах сангийн актив, үнэт цаасны төрөл, хувь хэмжээ;

5.2.2. талуудын эрх, үүрэг;

5.2.3. сангийн нэгж эрхийг эргүүлэн худалдаж авах зохицуулалт;

5.2.4. үйлчилгээний төлбөр, урамшуулал болон түүнтэй холбоотой бусад мэдээлэл;

5.2.5. хөрөнгө итгэмжлэн удирдах хөрөнгийн удирдлага;

5.2.6. гэрээг цуцлах үндэслэл, журам;

5.2.7. давагдашгүй хүчин зүйл (форс-мажор)-ийн нөхцөлүүд;

5.2.8. хэрэглэх хууль тогтоомжийн хүрээ болон маргаан шийдвэрлэх журам;

5.2.9. хуулиар хориглоогүй бусад шаардлагатай мэдээлэл.

5.3. Энэ журмын 5.1-д заасан гэрээнд өөрөөр заагаагүй бол ХОМК-ийн үйлчилгээний хөлс, урамшууллын хэмжээг нэмэгдүүлэх, хөрөнгө итгэмжлэн удирдах хугацаанд өөрчлөлт оруулах асуудлыг зөвхөн хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигч гишүүдийн хурлын шийдвэрээр өөрчлөлт оруулна.

5.4. Энэ журмын 5.3-д заасны дагуу гэрээнд орсон өөрчлөлтийг ажлын гурван өдрийн дотор Хороо болон сангийн нэгж эрх эзэмшигчид мэдээлнэ.

Зургаа. ХОМК-ийн үүрэг

6.1. ХОМК Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 44.8, 47.2-т заасан нийтлэг үүргээс гадна дараах үүргийг хэрэгжүүлнэ:

6.1.1. Хорооноос баталсан “Компанийн засаглалын кодекс”-ийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллах;

6.1.2. хөрөнгө оруулагчийн эрх ашгийг тэргүүн ээлжид тавьж, сонирхлын зөрчилгүй, бие даасан, хараат бус үйл ажиллагаа явуулах;

6.1.3. ХОС-ийн хөрөнгө оруулалтын багц, эрсдэлийн удирдлагыг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн нийтлэг стандарт зөвлөмж, сангийн дотоод дүрэм, журмын хүрээнд хэрэгжүүлэх;

6.1.4. хамтын ХОС-ийн хувьд хөрөнгө оруулалт хийх боломжтой хөрөнгө оруулалтын хэрэгслийн талаар төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулах;

6.1.5. хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичиг, стратегийн хүрээнд сангийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийж, хөрөнгө оруулагчдын оруулсан хөрөнгийн өгөөжийг нэмэгдүүлэхэд шаардлагатай бүх хүчин чармайлт гаргаж ажиллах;

6.1.6. хамтын ХОС-ийн хувьд төлөөлөн удирдах зөвлөлийн зөвшөөрөлгүйгээр сангийн хөрөнгийг хадгалах, хөрөнгө итгэмжлэн удирдахтай холбоотой аливаа гэрээ, хэлцлийг тухайн сангийн нэрийн өмнөөс байгуулахгүй байх;

6.1.7. нэгээс дээш тооны ХОС-д үйлчилгээ үзүүлж байгаа тохиолдолд сан тус бүрийн хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичиг, стратеги, дотоод дүрэм, журмын хүрээнд хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх, тэдгээрийн хооронд сонирхлыг зөрчил үүсгэхээс сэргийлж, шударга, ил тод байх зарчмыг мөрдөж ажиллах;

6.1.8. харилцагчийг таньж мэдэх, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс сэргийлэх чиглэлээр сангийн дотоод дүрэм, журам, хөтөлбөрт заасан арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлэх;

6.1.9. ХОМК-ийн эрх бүхий албан тушаалтан, хөрөнгө оруулалтын зөвлөх нь ёс зүйн дүрмийг үйл ажиллагаандаа тогтмол мөрдөж ажиллах;

6.1.10. ХОС-ийн нягтлан бодох бүртгэл хөтөлж, үйлчилгээ үзүүлж буй Хороонд бүртгэлтэй мэргэшсэн нягтлан бодогч өөрчлөгдсөн тохиолдолд энэ талаарх мэдээллийг тухай бүр Хороонд ирүүлэх.